



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2023/25/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2023 оны 02 дүгээр сарын 20</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866      Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5.1 Төлбөрийн акт .....	17
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/66

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

БАЯНХОНГОР АЙМГИЙН БААЦАГААН  
СУМЫН ЕБС-ИЙН ТӨСВИЙН  
ЗАХИРАГЧ Г.НАСАНБЯАР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### Аудитын гол асуудал

Тухайн байгууллага нь хичээл практик, цахим хэрэглээний зардал, багшийн тасралтгүй хөгжлийн үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, захиран зарцуулах, хяналт тавих багийг томилон ажилласан боловч зориулалт бусаар зарцуулсан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

005020296  
D/2023-A4 Alban toot

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 93.3 хувиар үнэлсэн байна.

Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРГӨӨДӨХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

D/2023-A4 Alban toot

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>154,459,247.08</b>	<b>180,962,241.95</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	23,265,680.79
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	23,265,680.79
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	23,265,680.79
31211	Төрийн сангийн харилцах	00.00	23,265,680.79
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	8,773,900.00	11,982,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	8,773,900.00	11,982,000.00
3351	Байгууллагаас авах авлага	8,773,900.00	11,982,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	145,685,347.08	145,714,561.16
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	4,298,600.00	2,606,800.00
35110	Тусгай зориулалттай материал	1,254,500.00	1,254,500.00
35130	Эм боох материал	3,044,100.00	1,352,300.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	141,386,747.08	143,107,761.16
35410	Бичиг хэргийн материал	6,339,332.08	7,963,987.16
35420	Аж ахуйн материал	131,504,915.00	130,846,774.00
35460	Хүнсний материал	39,000.00	793,500.00
35470	Бусад хангамжийн материал	3,503,500.00	3,503,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>695,255,679.71</b>	<b>697,475,170.01</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	695,255,679.71	697,475,170.01
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	654,679,679.71	656,899,170.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	597,092,445.36	597,092,445.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	-126,662,950.27	-156,892,934.97
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	352,654,231.36	414,319,231.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-252,907,398.39	-275,364,165.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	158,442,132.26	158,442,132.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	-119,021,465.22	-125,592,723.05
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,000,000.00	12,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,895,833.19	-8,083,333.16
39217	Ном	40,978,517.80	40,978,517.80
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	40,576,000.00	40,576,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	40,576,000.00	40,576,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>849,714,926.79</b>	<b>878,437,411.96</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>849,714,926.79</b>	<b>878,437,411.96</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	849,714,926.79	878,437,411.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	824,983,989.49	824,983,989.49
51101	Өмч: - төрийн	824,983,989.49	824,983,989.49
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-5,223,573.19	23,498,911.98
51210	Өмнөх үеийн үр дүн	-5,223,573.19	-5,223,573.19
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	28,722,485.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	29,954,510.49	29,954,510.49
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>849,714,926.79</b>	<b>878,437,411.96</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**/төгрөгөөр/**

**Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>Дансны код</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Өмнөх оны гүйцэтгэл</b>	<b>Тайлант оны гүйцэтгэл</b>
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,133,418,606.52</b>	<b>1,360,515,355.08</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>28,016,527.52</b>	<b>41,658,155.08</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	28,016,527.52	41,658,155.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,016,527.52	41,658,155.08
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,939,200.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	27,803,587.52	36,493,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	212,940.00	3,225,955.08
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,105,402,079.00</b>	<b>1,318,857,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	969,845,000.00	1,138,852,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,138,852,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	969,845,000.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	31,278,495.00	1,470,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,944,590.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,333,905.00	1,470,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	104,278,584.00	178,535,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104,278,584.00	178,535,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,122,541,878.41</b>	<b>1,331,792,869.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,122,541,878.41</b>	<b>1,331,792,869.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,066,045,897.83	1,269,966,907.93
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	738,852,001.97	847,459,838.41
210101	Үндсэн цалин	738,852,001.97	807,526,000.75
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	39,933,837.66
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	95,070,314.45	105,130,104.82
210201	Тэтгэврийн даатгал	88,916,554.28	105,130,104.82
210202	Тэтгэмжийн даатгал	1,532,576.74	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,225,978.43	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	308,655.04	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,086,549.96	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	103,278,584.00	111,182,390.00
210301	Гэрэл, цахилгаан	5,850,447.00	9,372,329.00
210302	Түлш, халаалт	96,798,137.00	99,160,061.00
210303	Цэвэр, бохир ус	630,000.00	2,650,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,135,005.00	6,049,625.00
210401	Бичиг хэрэг	3,276,835.00	4,855,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,438,140.00	00.00
210404	Ном, хэвлэл	503,180.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	355,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,361,850.00	1,194,525.00

**Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	38,054,650.00	82,544,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,552,250.00	4,355,800.00
210502	Хоол, хүнс	30,257,400.00	76,951,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	245,000.00	1,238,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,516,600.00	10,104,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,600,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,916,600.00	10,104,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	406,200.00	1,571,600.00
210702	Дотоод албан томилолт	406,200.00	1,571,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,709,900.00	9,037,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,209,900.00	2,158,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	6,878,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	64,022,642.41	96,886,749.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.00	32,668,840.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	195,000.00	4,772,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,427,642.41	59,445,509.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	56,495,980.58	61,825,961.98
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	49,243,640.00	50,382,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,362,000.00	50,382,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,944,590.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	937,050.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	7,252,340.58	11,443,661.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,252,340.58	11,443,661.98
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>10,876,728.11</u></b>	<b><u>28,722,485.17</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>10,876,728.11</u></b>	<b><u>28,722,485.17</u></b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,105,402,079.00</u></b>	<b><u>1,320,796,400.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>1,939,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	1,939,200.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	1,939,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,939,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,105,402,079.00</b>	<b>1,318,857,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	969,845,000.00	1,138,852,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,138,852,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	969,845,000.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	31,278,495.00	1,470,000.00

**Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,806,300.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,944,590.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	527,605.00	1,470,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>104,278,584.00</b>	<b>178,535,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104,278,584.00	178,535,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,088,539,039.00</b>	<b>1,272,358,719.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,088,539,039.00</b>	<b>1,272,358,719.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,026,361,758.42</b>	<b>1,197,033,257.23</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>739,194,614.03</b>	<b>847,498,019.90</b>
210101	Үндсэн цалин	572,348,459.47	577,907,096.81
210102	Нэмэгдэл	118,292,454.91	203,457,574.63
210104	Урамшуулал	48,553,699.65	26,199,510.80
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	39,933,837.66
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>94,724,005.39</b>	<b>105,091,923.33</b>
210201	Тэтгэврийн даатгал	69,941,364.86	71,975,227.99
210202	Тэтгэмжийн даатгал	6,212,811.36	8,453,685.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,970,049.07	6,762,420.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,284,162.27	1,627,180.71
210205	Эрүүл мэндийн даатгал	12,315,617.83	16,273,409.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>103,278,584.00</b>	<b>111,182,390.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,223,645.00	9,372,329.00
210302	Түлш, халаалт	96,424,939.00	99,160,061.00
210303	Цэвэр, бохир ус	630,000.00	2,650,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,429,450.00</b>	<b>00.00</b>
210401	Бичиг хэрэг	3,131,300.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,138,290.00	00.00
210404	Ном, хэвлэл	982,160.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,240,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,737,700.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>40,658,700.00</b>	<b>64,206,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,515,300.00	00.00
210502	Хоол, хүнс	23,387,500.00	64,206,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,755,900.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,771,900.00</b>	<b>11,000,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,600,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,171,900.00	11,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>406,200.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	406,200.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,657,505.00</b>	<b>10,938,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,917,505.00	2,846,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00

**Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	8,092,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,240,800.00</b>	<b>47,116,124.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,700,000.00	34,815,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,540,800.00	12,300,624.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛҮҮЛЭГ</b>	<b>62,177,280.58</b>	<b>75,325,461.98</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>54,924,940.00</b>	<b>63,881,800.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,043,300.00	63,881,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,944,590.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	937,050.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>7,252,340.58</b>	<b>11,443,661.98</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,252,340.58	11,443,661.98
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>16,863,040.00</u></b>	<b><u>48,437,680.79</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>16,863,040.00</b>	<b>25,172,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>16,863,040.00</b>	<b>25,172,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>16,863,040.00</b>	<b>25,172,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,863,040.00	25,172,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-16,863,040.00</u></b>	<b><u>-25,172,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>23,265,680.79</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>23,265,680.79</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	824,983,989.49	29,954,510.49	-16,100,301.30	838,838,198.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>824,983,989.49</b>	<b>29,954,510.49</b>	<b>-16,100,301.30</b>	838,838,198.68
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,876,728.11	10,876,728.11
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>824,983,989.49</b>	<b>29,954,510.49</b>	<b>-5,223,573.19</b>	849,714,926.79
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	<b>824,983,989.49</b>	<b>29,954,510.49</b>	<b>-5,223,573.19</b>	849,714,926.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>824,983,989.49</b>	<b>29,954,510.49</b>	<b>-5,223,573.19</b>	849,714,926.79
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	28,722,485.17	28,722,485.17
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>824,983,989.49</b>	<b>29,954,510.49</b>	<b>23,498,911.98</b>	878,437,411.96

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
-----	----------	------------	-----------	-----	------

Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,319,322,700.00	1,284,617,057.23	34,705,642.77	97.4
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,319,322,700.00	1,284,617,057.23	34,705,642.77	97.4
4	Бараа, үйлчилгээний зардал	1,250,541,300.00	1,220,735,257.23	29,806,042.77	97.6
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	862,679,400.00	847,498,019.90	15,181,380.10	98.2
6	Үндсэн цалин	622,528,000.00	577,907,096.81	44,620,903.19	92.8
7	Нэмэгдэл	181,866,400.00	203,457,574.63	(21,591,174.63)	111.9
9	Урамшуулал	18,351,100.00	26,199,510.80	(7,848,410.80)	142.8
10	Гэрээт ажлын хөлс	39,933,900.00	39,933,837.66	62.34	100.0
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,818,600.00	105,091,923.33	2,726,676.67	97.5
12	Тэтгэврийн даатгал	73,377,500.00	71,975,227.99	1,402,272.01	98.1
13	Тэтгэмжийн даатгал	8,610,700.00	8,453,685.31	157,014.69	98.2
14	ҮОМШӨ ний даатгал	6,888,000.00	6,762,420.24	125,579.76	98.2
15	Ажилгүйдлийн даатгал	1,721,900.00	1,627,180.71	94,719.29	94.5
16	Эрүүл мэндийн даатгал	17,220,500.00	16,273,409.08	947,090.92	94.5
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,625,900.00	111,182,390.00	11,443,510.00	90.7
18	Гэрэл цахилгаан	10,124,600.00	9,372,329.00	752,271.00	92.6
19	Түлш, халаалт	109,851,300.00	99,160,061.00	10,691,239.00	90.3
20	Цэвэр, бохир ус	2,650,000.00	2,650,000.00	-	100.0
30	Нормативт зардал	64,207,000.00	64,206,000.00	1,000.00	100.0
32	Хоол, хүнс	64,207,000.00	64,206,000.00	1,000.00	100.0
34	Эд хопшил худалдан авах	11,000,000.00	11,000,000.00	-	100.0
38	Урсгал засвар	11,000,000.00	11,000,000.00	-	100.0
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	9,579,100.00	9,470,800.00	108,300.00	98.9
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,378,500.00	1,378,500.00	-	100.0
49	Мэдээллийн технологийн зардал	8,200,600.00	8,092,300.00	108,300.00	98.7
53	Бараа үйлчилгээний бусад зардал	72,631,300.00	72,286,124.00	345,176.00	99.5
54	Бараа үйлчилгээний бусад зардал	57,638,400.00	59,985,500.00	(2,347,100.00)	104.1
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,992,900.00	12,300,624.00	2,692,276.00	82.0
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,781,400.00	63,881,800.00	4,899,600.00	92.9
70	Бусад урсгал шилжүүлэг	68,781,400.00	63,881,800.00	4,899,600.00	92.9
74	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	68,781,400.00	63,881,800.00	4,899,600.00	92.9
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,319,322,700.00	1,307,882,738.02	11,439,961.98	100.0
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,138,852,000.00	1,138,852,000.00	-	99.8

**Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

99	Улсын төсвөөс санхүүжих	1,138,852,000.00	1,138,852,000.00	-	99.8
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	178,535,200.00	167,091,538.02	11,443,661.98	100.0
104	Орон нутгийн төсвөөс	178,535,200.00	167,091,538.02	11,443,661.98	100.0
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,935,500.00	1,939,200.00	(3,700.00)	-
111	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,935,500.00	1,939,200.00	(3,700.00)	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	23,265,680.79	(23,265,680.79)	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	62	58	4	93.5
134	Удирдах ажилтан	1	1	-	100.0
135	Гүйцэтгэх ажилтан	44	40	4	90.9
136	Үйлчлэх ажилтан	17	17	-	100.0
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	1	1	-	100.0
139	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	1	1	-	100.0
140	Төрийн өмчит ЕБС	1	1	-	100.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Эх хэлээр алдаагүй зөв цэвэр сайхан бичдэг, өөрийгөө илэрхийлэх чадвартай, мэндлэх, хүндлэх ёсыг дээдэлдэг цэвэр нямбай хүүхэд төлөвшүүлнэ” гэсэн зорилготой ажиллаж байна.

2022-2023 оны хичээлийн жилд өдрөөр 563 хүүхэд, дүйцсэн хөтөлбөрт 24 суралцагч, 150 хүүхдийн хүчин чадалтай дотуур байранд 106 хүүхэд, 306 хүүхэд үдийн цай хөтөлбөрт хамрагдсан байна

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын алба байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийн аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг бөгөөд Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Богд сумын Ерөнхий боловсролын сургууль нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 878,437.4 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 28,722.5 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	23,265.7	23,265.7
Авлага	8,773.9	11,982.0	3,208.1
Бараа материал	145,685.3	145,714.6	29.2
Үндсэн хөрөнгө	1,202,043.3	1,263,708.3	61,665.0
Хуримтлагдсан элэгдэл	(506,787.6)	(566,233.2)	(59,445.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>849,714.9</b>	<b>878,437.4</b>	<b>28,722.5</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	849,714.9	878,437.4	28,722.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>849,714.9</b>	<b>878,437.4</b>	<b>28,722.5</b>

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд үлдэгдэлгүй байсан бөгөөд тайлант оны эцэст улсын төсвийн санхүүжилтийн үлдэгдэл 23,265.7 мянган төгрөг үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл 11,982.0 мянган төгрөг болж 3,208.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд цахим дэлгүүрээс ерөнхий гэрээний дагуу АЙ ТИ

ЗОН ХХК-аас тоног төхөөрөмж худалдан авахаар 11,982.0 мянган төгрөгийг шилжүүлж тоног төхөөрөмжөө хүлээн аваагүйгээс үүссэн авлагатай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 145,714.6 мянган төгрөг болж өмнөх оноос 29.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 173,138.7 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 3,226.0 мянган төгрөгийн хөрөнгө орлого авч, 176,335.5 мянган төгрөгийн төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,263,708.3 мянган төгрөг болж 61,665.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 25,172.0 мянга, БШУЯ-аас 34,107.0 мянга, НҮБ-ийн хүүхдийн ивээх сангаас 2,386.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 878,437.4 мянган төгрөг болж 28,722.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 28,722.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,296,688.4 мянга, нийт зарлагыг 1,296,688.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 251,011.9 мянган төгрөгөөр бууруулж 1,045,676.5 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 1,319,322.7 мянган төгрөг болгож 273,646.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 80226, 80312, 81605, 81816, 81823, 81834, 81835, 80112 арга хэмжээг санхүүжүүлэхээр 600,78.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 530,464.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 70,324.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,138,852.0 мянга, орон нутгийн төсвөөс 178,535.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй орон нутгийн төсвийн санхүүжилтээс 11,443.7 мянган төгрөгийг буцаан орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,284,617.1 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 34,705.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

**Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>1</b>	<b>71802 Ерөнхий боловсрол</b>	<b>1,319,322.7</b>	<b>1,284,617.1</b>	<b>34,705.6</b>	97.4
2	80226 Байр ашиглалтын зардал	3,280.2	3,280.2	0.0	100.0
3	80312 Сургалт семинарын зардал	1,640.1	1,640.0	0.1	100.0
4	81605 Эрүүл мэндийг дэмжих зардал	3,772.3	3,740.0	32.3	99.1
5	81801 Үдийн цай хөтөлбөр	68,781.4	63,881.8	4,899.6	92.9
6	81806 Дотуур байрны үйлчилгээ	93,269.1	92,526.6	742.5	99.2
7	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	37,465.0	37,154.0	311.0	99.2
8	81823 Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	7,380.5	7,379.0	1.5	100.0
9	81834 Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	830,147.3	814,847.8	15,299.5	98.2
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	93,116.1	91,140.6	1,975.5	97.9
11	81848 Сурах бичгийн түрээсийн зардал	1,378.5	1,378.5	0.0	100.0
12	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	557.0	557.0	0.0	100.0
13	80112 Нийтлэг үйлчилгээ	178,535.2	167,091.5	11,443.7	93.6
	<b>Нийт дүн</b>	<b>1,319,322.7</b>	<b>1,284,617.1</b>	<b>34,705.6</b>	97.4

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй ба нийт 1470.0 мянган төгрөгийг ирснийг зориулалтын дагуу зарцуулсан

**Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого**

/мян.төг/

д/д	Орлогын төрөл	Авсан санхүүжилт
1	Заалны орлого	970.0
2	Төслийн мөнгө/Газрын доорхи усыг таниулья сэдэвт сургалт нөлөөлөл зохион байгуулах тэтгэлэгт төсөл/	500.0
	<b>Нийт орлогын дүн</b>	<b>1,470.0</b>

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны

12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дүгээр сарын 20-ны өдрийн 49 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Бумтирмаа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Э.Адъяа нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,319,322.7 мянган төгрөгөөс тооцоход 19,789.8 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 13,852.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 104 мэдээлэл хугацаандаа оруулж 40 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 мэдээлэл мэдээлээгүй байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10 гүйлгээний 199,241.1 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроосон, 20 гүйлгээний 379,420.3 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй, зарлагын 7 мөнгөн гүйлгээний 66,907.0 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна. Тендерт шалгарсан 23,460.0 мянган төгрөгийн 3 гэрээ, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн халаалт, дотуур байр үдийн цайны гэрээтэй холбоотой 3 гэрээний 122,620.0 мянган төгрөгийн мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

**Хүснэгт 3. Шилэн дансны мэдээлэл**

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	2	3	4	2
2	Хагас жил	4	4	3	0	1	
3	Улирал бүр	1	4	3	1		
4	Сар бүр	3	36	30	6		
5	Тухай бүр	8	96	66	30		
	Нийт	27	151	104	40	5	2

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, тендерийн худалдан ажиллагааны мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх албан шаардлагыг хүргүүлэв.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Засварын аудитыг хийсэн ба алдааны дүнг жилийн эцэст нэгтгэн танилцуулав.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 3,067.5 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 3,067.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлсэн ба Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2022.05.30-ны өдрийн 40 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3,067.5	1	3,067.5	100
Албан шаардлага	1	0	1	0	100
Зөвлөмж	1	0	1	0	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>3,067.5</b>	<b>3</b>	<b>3,067.5</b>	<b>100</b>

Эх сурвалж: 2021 оны аудитын тайлангаас

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар Үдийн цай хөтөлбөрийн зардал 4899.6 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,300.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1,082.1 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 22,216.9 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хүргүүлэв.

##### 5.1 Төлбөрийн акт

1. Хичээл практикийн зардлаас Галуут Хан уул ХХК-д корданы үнэ 160.0 мянга, албан тоот худалдан авахад 88.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 1.4-т "Хичээл практикийн зардалд цэцэрлэг, ЕБС-ийн хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах цаас, шохой бал, маркер, принтер болон хувилагч машины хор, судлагдахууны онцлогтойгоор туршилт дадлагын явцад ашиглах жижиг багаж хэрэгсэл, урвалж бодис, хэмжилт хийх багаж, лаа, зай, тугалган цаас, зүү, утас, даавуу, хадаас, мод материал, бэлдэц, хөгжмийн утас, хөгжмийн энгийн зэмсэг, бөмбөг, дасгал хийхэд хэрэглэх энгийн хэрэгсэл гэх зэрэг бага үнэтэй, түргэн элэгдэх хангамжийн материал, хэрэглэгдэхүүн худалдан авах зардал багтана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зориулалт бусаар зарцуулсан корданы үнэ 248.5 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардалд тайлант 7,379.0 мянган төгрөг зарцуулсан бөгөөд сургуулийн үйл ажиллагааны урсгал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зардлаас зарцуулах аж ахуйн материалын 709.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт түүнийг зарцуулах заавар"-ын 1.3.-т Багшийн хөгжлийн зардлыг цэцэрлэг, ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих, ур чадварыг сайжруулах сургалт, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зориулалт бусаар зарцуулсан аж ахуйн материалын үнэ 709.0 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Сургалтын менежер Ц.Пагмадулам 2022.04.04-ны өдөр Улаанбаатар хот руу явах 6 хоногийн албан томилолтын хуудас бичүүлсэн байтал 2022.04.02-2022.04.04 хүртэл Баянхонгорт ажилласан 2 хоногийн 34.6 мянга, Улаанбаатар хотод 5 хоног томилолтоор ажилласан байтлаа 6 хоногоор буудлын хөлсөнд 90.0 мянга нийт 124.6 мянган төгрөг илүү авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 2 дугаар зүйлийн 2.4-т "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү олгосон 124.6 мянган төгрөгийг албан томилолтыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

Тус байгууллага нь хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлаас 12,300.6 мянга, цахим хэрэглээний зардлаас 8,092.3 мянган төгрөгийг тус тус зарцуулахдаа Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалыг мөрдөөгүй байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 3.3-т "Энэ зааврын 3.2-т заасан хуваарийн дагуу сургалтад ашиглах материал, хэрэглэгдэхүүнийг сонгох, худалдан авах, заах аргын нэгдэл/секцийн ахлагчид хүлээлгэн өгөх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлын тушаалаар тус тус томилон ажиллуулна" Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан "Цэцэрлэг, ЕБС-ийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 3.2-т "Зааврын 3.1-д заасан баг нь хичээлийн жилийн турш үйл ажиллагааг зохион байгуулна гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгч Төсвийн тухай

хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчиж төсвийг зориулалт бусаар зарцуулсан төсвийн захирагчид Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах саналыг томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 5.3 Зөвлөмж

2. Эрүүл мэндийг дэмжих зардлаас тайлант онд цагаан хорхойн шинжилгээнд 18 багш ажилтанд 540.0 мянга, хэвлийн хэт авайн оношилгоо бүх багш ажиллагсад 1,680.0 мянга, бамбайн шинжилгээ багш ажилчдад 1.520.0 мянган төгрөг нийт 3.740.0 мянган төгрөгийн зардал гарсан байна.

Энэ нь Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022.06.29-ны өдрийн А/238, А/340 дугаар тушаалын 2.1-т " Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоонд хавсралтад заасан хугацааны дагуу хамруулах" гэсэн заалтыг зөрчсөн байна

Өгсөн зөвлөмж: Цаашид Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022.06.29-ны өдрийн А/238, А/340 дугаар тушаалын 2.1-т заасан үзлэг оношилгоонд хамруулах зөвлөмжийг хүргүүлж байна.

2. Цахим хэрэглээний зардлаас санхүүгийн программын сунгалтын зардалд 385.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан "Цэцэрлэг , ЕБС-ийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 1.4-т "Цахим хэрэглээний зардалд цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай дата, цахим систем, цахим эрх бусад мэдээлэл технологийн ашиглалтын зардал багтана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цахим хэрэглээний зардлыг зориулалтын дагуу зарцуулж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хичээл практикийн зардлаас зориулалт бусаар зарцуулсан 248.5 мянган төгрөгийг зарцуулсан байна	1	248.5	1	248.5				
Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардлаас аж ахуйн материалын 709.0 мянган төгрөгийг зарцуулсан байна	1	709.0	1	709.0				
Сургалтын менежер Ц.Пагмадуламд 124.6 мянган төгрөгийн илүү томилолт олгосон байна.	1	124.6	1	124.6				
Хичээл практикийн үйл ажиллагааны зардлыг төлөвлөх захиран зарцуулах, хяналт тавих баг, цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, захиран зарцуулах баг томилоогүй байна	1	20,392.9			1	20,392.9		
Цахим хэрэглээний зардлаас зориулалт бусаар 385.0 мянган төгрөг зарцуулсан байна.	1	385.0					1	385.0
Эрүүл мэндийн дэмжих зардлаас багш, ажилчдыг сайдын тушаалаар батлагдсан үзлэг, шинжилгээнээс өөр үзлэг оношилгоонд хамруулсан байна	1	1824.0					1	1,824.0
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>23,684.0</b>	<b>3</b>	<b>1,082.1</b>	<b>1</b>	<b>20,392.9</b>	<b>2</b>	<b>2,209.0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10 гүйлгээний 199,241.1 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроосон, 20 гүйлгээний 379,420.3 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй, зарлагын 7 мөнгөн гүйлгээний 66,907.0 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна. Тендерт шалгарсан 23,460.0 мянган төгрөгийн 3 гэрээ, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн халаалт, дотуур байр үдийн цайны гэрээтэй холбоотой 3 гэрээний 122,620.0 мянган төгрөгийн мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.	1	0	0	0	1	0	0	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>

ooOoo